



ДУНДГОВЬ АЙМАГ
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/56.

Рашаант

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1, 11.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн дугаар А/276 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өлзийт сумын Дэрт-2, Буянтын 1, 2-р багийн нутаг дэвсгэр дээр Малын гоц халдварт шүлхий өвчин гарсан тул хорио цээрийн дэглэмийг 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатайгаар "Лог үнстий"-ээс сумын зүүн хилийг тойрч "Долоон"-ны худаг хүртэл нийт 318 километрт хорио цээрийн дэглэм тогтоосугай.

Хоёр. Голомтын бүсэд малын шилжилт хөдөлгөөн, баяр ёслол, морины уралдаан болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх, хил залгаа аймаг, сумаас оторчид оруулах, өөрийн сумын баг дотор сэлгэн нүүх, малын гаралтай мах болон бусад түүхий эд тээвэрлэхийг хориглосугай.

Гурав. Малын гоц халдварт шүлхий өвчин гадагш тархахаас хамгаалж хорио цээрийн дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах хяналтын пост-д техник хэрэгсэл хүн хүчийг дайчлан гаргаж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Хорлоо/-д арга хэмжээнд шаардагдах зардлыг Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сангуудаас гаргахыг Санхүүгийн албаны дарга /Б.Болдбаатар/, Нийтийн ерөнхий үйлчилгээ хариуцсан нягтлан бодогч /Н.Буянжаргал/ нарт даалгасугай.

Дөрөв. Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга малын эмч С.Хүүхэнбаатар, малын эмч Д.Баярсайхан, малын эмч Ч.Цэцэг нарт малын гоц халдварт өвчний талаар мал бүхий малчдыг мэргэжлийн удирдлага арга зүйн мэдээллээр хангаж, мөн малчид, иргэдэд тус өвчний талаар урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж, мэдээ мэдээллийг шуурхай хүргэж, тухай бүр хяналт тавьж, ажлын явцыг танилцуулж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга /Ж.Рэнчинсамбуу/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  И.ЭРДЭНЭБИЛЭГ



050170